

# УВС АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ ЭХНИЙ УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

*/1 дүгээр улирал/*

2020.04.02

Улаангом

## **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

*1.1. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг ханагх чиглэлээр:*

Тус цагдаагийн газар нь Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 261, 2018 оны 42, 2007 оны 175, 2010 оны 289, 2015 оны 346, 2017 оны 98, 321, 142, 299, 143, 270, 2018 оны 50, 163, 2019 оны 163 дугаар тогтоол, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 13, 104, 2020 оны 10 дугаар зарлиг, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2013 оны 02, 2015 оны 28, 2016 оны 10, 2018 оны 02, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 19/15, 2018 оны 06/05, 12/09, 2019 оны Н-41/25 дугаар зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 27, 142, 195, 196, 249, 2018 оны 34, 258, 2019 оны 33, 57, 355, 2020 оны 17, 30, 62, 63 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 68 дугаар захирамж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 1 дүгээр хуралдааны тэмдэглэл, 2017 оны 39, 44, 48, 2018 оны 21, 2019 оны 15, 42, 51, 2020 оны 10 дугаар хуралдааны тэмдэглэл болон ЦЕГ-ын даргын тушаал, албан даалгавар даалгавар, үүрэг, ЦЕГ-ын Тэргүүн дэд болон дэд дарга нараас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл зэрэг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/65 дугаар тушаалаар баталсан "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд хяналтанд авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ хийх, биелэлт үр дүнг тооцох баримт бичиг"-ийг хариуцан тайлагнах ажлыг тасгийн дарга нарт хариуцуулан зохион байгуулж байгаа ба дээр дурьдсан нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хамаарах нийт 142 эрх зүйн акт, баримт бичгүүдийн биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр тооцуулахаар хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн баримт бичгүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг нэмэгдүүлэх, зорилгоор шийдвэр, үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж буй холбогдох алба, нэгжтэй тухайн тасгийн дарга нар байнга холбоотой ажиллаж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнан ажиллаж байна.

Тасгийн дарга болон биелэлт үр дүнг хариуцсан алба хаагчдад баримт бичгийн биелэлт үр дүнг тайлагнахад анхаарах асуудлын талаар Захиргааны удирдлагын тасгийн дарга мэдээлэл хийж, бичгээр зөвлөмж өгсөн.

Барит бичиг, үйл ажиллагааны хэрэгжилтийг цагдаагийн газрын дарга биечлэн хянаж, цахим гарын үсэг зурж, тэмдэг дарж албажуулан холбогдох алба, нэгжид хүргүүлэн ажиллаж байна.

Үүний үр дүнд энэ оны эхний улиралд бичиг баримтийн хэрэгжилтийн хугацаа хоцроосон, тайлагнахгүй орхигдуулсан зөрчил гараагүй байна.

## 1.2. Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, тушаал, шийдвэрийн талаар

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар 2020 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг жилээр гаргаж, цагдаагийн газрын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын ээлжит хуралдааныг даргын тушаалаар тогтсон өдөр, цагт явуулж, ээлжит бус хуралдааныг зайлшгүй шаардлагатай гэж үзвэл даргын товлон зарласнаар хуралдуулж байна.

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. Үүнд:

1. Цагдаагийн төв байгууллагын дарга болон дээд шатны байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, бусад шийдвэрүүд, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай асуудал;

2. Хүний нөөцийн асуудал;

3. Цагдаагийн газрын санхүү, төсвийн асуудал;

4. Цагдаагийн газрын үндсэн үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал;

5. Цагдаагийн газарт мөрдөгдөх журам, заавар, тушаалын төсөл;

6. Цагдаагийн газрын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой тулгамдаж буй асуудал зэргийг хэлэлцэж байна.

Тус цагдаагийн газрын даргын зөвлөл энэ оны эхний улиралд 8 удаа хуралдаж хурлыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Даргын зөвлөл байгуулах, асуудал хэлэлцэх /код 104/ журам”-ын дагуу явуулж, нийт 46 тушаал, шийдвэр гаргасан байна.

## 1.3. Хүний нөөцийн талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/135 дүгээр тушаалын 19 дүгээр хавсралтаар тус цагдаагийн газрын бүтэц, орон тоог 161 орон тоотойгоор баталсан ба удирдах албан тушаалтан 1, гүйцэтгэх албан тушаалтан 157, хөдөлмөрийн гэрээгээр /ТҮ/ ажиллагсад 3 байгаагаас 2018 онд Өмнөговь сум дахь цагдаагийн хэсгийн цагдаагийн 1 орон тоог ЦЕГ-ын Сүлд чуулгад шилжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/17 дугаар тушаалаар тус цагдаагийн газрын бүтэц, орон тоонд экологийн асуудал хариуцсан ахлах мөрдөгчийн орон тоог нэмж нийт 161 орон тоотой болсон.

Тус цагдаагийн газарт одоо ажиллаж байгаа алба хаагчдын 75 буюу 47.4 хувь нь төсөвт офицер, 76 буюу 48.1 хувь нь төсөвт ахлагч, 4 буюу 2.5 хувь нь гэрээт ахлагч, 3 буюу 1.8 хувь нь төсөвт энгийн ажилчид байгаа ба 2 офицер, 1 ахлагч буюу нийт 3 орон тоо сул байна.

Нийт бүрэлдэхүүний 144 буюу 91.1 хувь нь эрэгтэй, 14 буюу 8.9 хувь нь эмэгтэй алба хаагч байгаа бөгөөд насны ангилалаар нь авч үзвэл 18-25 настай 51 буюу 32.2 хувь, 26-35 настай 75 буюу 47.4 хувь, 36-45 настай 28 буюу 17.7 хувь, 45-аас дээш настай 4 буюу 2.5 хувийг эзэлж байна.

Алба хаагчдыг боловсролынх нь түвшингээр нь ангилж үзвэл 126 буюу 79.7 хувь нь дээд, 4 буюу 2.5 хувь нь тусгай дунд, 28 буюу 17.7 хувь нь бүрэн дунд боловсролтой байна.

Энэ оны 01 дугаар сард ЦЕГ-аас зарласан ажлын байрны сул орон тооны сонгон шалгаруулалтанд 12 иргэний хүсэлтийг хүлээн авч судлаж, эрүүл мэнд, бие

бялдар, сэтгэл зүй, монгол хэл бичгийн шалгалтыг авч, судлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Дэлхий дахинд тархсан шинэ төрлийн коронавирус /covid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гарсан шийдвэрийн дагуу Дотоод хэргийн Их сургуулийн ахлагчийн сургуулийн элсэлтийн шалгалтыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан тул сонгон шалгаруулалтын судалгааг энэ хугацаанд үргэлжүүлэн явуулж байна.

Энэ оны эхний улирлын байдлаар албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, мэргэжил, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн 1 алба хаагчийг ахлах албан тушаалд дэвшүүлэх, 1 алба хаагчийг офицерын орон тоонд дадлагажих ажилтнаар томилуулах, 5 алба хаагчийг шилжүүлэн томилуулах, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн 1 иргэнийг нөөцөөс шинээр томилуулах саналыг ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Мөн алба хаагчийн ажилласан жил, ажлын үр дүн, сахилга ёс зүйг үндэслэн “Цэргийн гавъяаны одон”-гоор 1, “Цэргийн хүндэт медаль”-иар 2, Хууль зүй дотоод хэргийн яамны “Хүндэт жуух”-аар 1 алба хаагчийг шагнуулахаар холбогдох материалыг бүрдүүлэн албадаар нь уламжлуулан Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

Одоо тус цагдаагийн газарт хэсгийн төлөөлөгч 1, сэтгэл зүйч 1, эргүүлийн цагдаа 1 нийт 3 ажлын байр сул байна.

Дээрх сул орон тоог нөхөх зорилгоор шалгуур шаардлага хангасан алба хаагчийг судлаж, сэтгэл зүйч болон эргүүлийн цагдаагийн сул орон тоонд томилуулах алба хаагч, иргэний /нөөцөд бүртгээгдсэн/ материалыг ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

#### *1.4. Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар:*

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны А/07 дугаар тушаалаар баталсан албаны сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, албанаас зохион байгуулагдаж байгаа сургалтын чанар үр дүнг сайжруулах, алба хаагчдын ажил мэргэжлийн онцлог, ажилласан жил, ур чадварт зохицсон шинэлэг байдлаар зохион байгуулах зорилгоор “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-г тус цагдаагийн газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/01 дугаар тушаалаар баталж, алба хаагчдад төлөвлөгөөний дагуу сургалтыг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна.

Сургалтыг батлагдсан төсвийн хүрээнд сургалтын баг болон гадны сургагч багш урьж зохион байгуулж байгаа ба аль болох шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, сургалтын мэдээллийг сургалтын нэгдсэн бүртгэлийн сан /Esurgalt/-д тухай бүр оруулан ажиллаж байна.

Албаны сургалт явуулах цаг, хугацааг цагдаагийн газрын “Дотоод журам”-д сар бүрийн 1, 3 дугаар долоо хоногийн “Лхагва” гарагт 16.00 цагаас зохион байгуулахаар тусгасан.

Мөн цагдаагийн газрын төрөл мэргэжлийн тасаг, хэсгүүд дотооддоо зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулж сар бүрийн 2 дахь долоо хоногийн “Баасан” гарагт сургалт зохион байгуулж байна.

Тус цагдаагийн газраас энэ оны эхний улиралд мэдвэл зохих хууль тогтоомжийн 12 удаагийн 16 цагийн сургалтанд 1615, алба хаагчийг хөгжүүлэх 5

удаагийн 7 цагийн сургалтанд 654, дадлагажуулах 3 удаагийн 4 цагийн сургалтанд 416, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан 1 удаагийн 1 цагийн сургалтад 151 алба хаагч, нийт 21 удаагийн 28 цагийн сургалтад 2836 /давхардсан тоогоор/ алба хаагч хамрагдсан байна.

### ***А. Мэдвэл зохих хууль, тогтоомжийн сургалтын талаар:***

Мэдвэл зохиох хууль тогтоомжийн сургалтын хүрээнд алба хаагчдад “Төрийн албаны тухай хуулийн ойлголт”, “Цагдаагийн албаны тухай хуулийн 4, 5 дугаар бүлэг”, “Шинэчлэн батлагдсан сонгуулийн тухай багц хуулийн ойлголт, үзэл баримтлал”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал”, “Зөрчлийн тухай хуулийн ойлголт /цагдаагийн алба хаагчаас зөрчил шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль”, “Авлигын эсрэг хууль”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/196 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн дотоод албаны дүрэм”, “Цагдаагийн хүрээний дүрэм”, “Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм”, “Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах”, “Төрийн болон албаны нууцыг хамгаалах”, “Төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнахад анхаарах асуудал /Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 47 дугаар тушаал” зэрэг 12 сэдвийн хүрээнд 16 цагийн сургалтыг зохион байгуулсан ба нийт давхардсан тоогоор 1615 алба хаагч хамрагдсан байна.

### ***Б. Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын талаар:***

Тус цагдаагийн газраас энэ оны эхний улиралд алба хаагчийг хөгжүүлэх сургалтыг лекц, зайн болон цахим хэлбэрээр 5 удаа зохион байгуулсан ба нийт 4 цагийн сургалтанд 416 алба хаагч/ давхардсан тоогоор/ хамрагдсан.

Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын хүрээнд алба хаагчдын дунд “Microsoft office програмууд дээр ажиллах чадвар”, “Мал хулгайлах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах зарим асуудал”, “Гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санд ажиллах аргачлал”, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын түүхэн замнал”, “Smart-Tablet”, “TPS3 -Google map дээр ажиллах болон ашиглахад анхаарах асуудлууд” зэрэг сэдвийн хүрээнд 5 удаагийн сургалтыг зохион байгууллаа.

### ***В. Дадлагажуулах сургалтын талаар:***

Батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу энэ оны эхний улиралд дадлагажуулах сургалтыг 3 удаа дадлага болон зайн /цахим/ хэлбэрээр зохион байгуулсан.

Цагдаагийн газрын нийт алба хаагчдад Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журам”, “Осол гэмтлийн үед анхны туслам үзүүлэх /ЦБҮАЖ код-209/”, Хамгаалах хувцас өмсөж хэрэглэхэд анхаарах асуудал” зэрэг сэдвийн хүрээнд 4 цагийн сургалтыг зохион байгуулсан ба давхардсан тоогоор 416 алба хаагч хамрагдсан.

## ***Г. Бусад сургалтын талаар:***

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулиар Хуулийн хэтсээс бэлтгэн ирүүлсэн гарын авлагыг ашиглан энэ оны 03 дугаар сарын 18-ны өдөр алба хаагчдад сургалт зохион байгуулсан.

Аймгийн прокурорын газартай хамтран нэмэлт өөрчлөлт орсон Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн сургалтыг эрх бүхий алба хаагчдад зохион байгууллаа.

Мөн цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад зориулсан “Галт зэвсэгтэй харьцах, ашиглах үеийн аюулгүй ажиллагааны зөвлөмж /13 минут/, “Галт зэвсэг хүлээлцэх үеийн аюулгүй ажиллагааны зөвлөмж” /5 минут/, “Галт зэвсэгтэй харьцахад гаргадаг нийтлэг алдаа, анхаарах асуудал” /9 минут/ сэдэвт цуврал видео сургалтыг цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн гарын авлага хэсгээс татаж авч алба хаагчдад үзүүлсэн.

Энэ оны эхний улирлын байдлаар тус цагдаагийн газрын алба хаагчдад 21 удаагийн 28 цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 2836 алба хаагч хамрагдсан байна.

### ***1.5. Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлэн ажил арга хэмжээ***

Алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, үүрэг гүйцэтгэх боломжийг хангахад анхаарч энэ оны эхний улиралд тус цагдаагийн газрын тасгийн дарга нар хариуцан алба хаагчдынхаа гэрээр нэгбүрчлэн зочилж, ахуй амьдралтай нь танилцаж, гэр бүлийн гишүүдээс санал асуулга авч, тухайн санал асуулыг үндэслэн цаашид алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудлын талаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг хангах, тогтвор суурьшилтай ажиллахад чиглэсэн дараах ажил, арга хэмжээг эхний 1 дүгээр улиралд авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2-д заасан болзол, шалгуурыг хангасан 2 алба хаагчийн материалыг бүрдүүлж, 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгуулсан.

2. Цагдаагийн газрын дундын сангаас шинээр хүүхэдтэй болсон 2 алба хаагчид 100000 төгрөг, ар гэрийн гачигдал гарсан 2 алба хаагчид 600000 төгрөг, эмчилгээ сувилгаанд явсан 2 алба хаагчид 400000 төгрөг, нийгмийн бусад асуудалд 500000 төгрөг, нийт 1600000 төгрөгийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн.

3. Цагдаагийн газрын 158 алба хаагч, ажилтанг гэнэтийн ослын даатгалд хамруулсан.

4. Хэсгийн 1 алба хаагчийн гэр бүлийг ажлын байраар хангуулсан

5. Хэсгийн байцаагч нарын дунд 1 автомашин шийдвэрлэсэн

6. Дэлхий дахинд тархсан шинэ төрлийн корона вирус /COVID-19/ ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор алба хаагчдад амны хаалт, хамгаалах хувцас, дархлаа дэмжих бүтээгдэхүүн /чацаргана, үхрийн нүд, аарц, хоормог г.м/ -ийг өгч, өрөө болгонд гар ариутгагч шингэн байрлуулж, ариутгал халдваргүйжилтийг 2 удаа хийлгэсэн.

7. Замын цагдаагийн тасагт 1, Нийтийн хэв журам хамгаалах тасагт 1, Эрүү, Мөрдөн байцаах тасагт 1, нийт 3 ширхэг приус 20 маркын автомашиныг худалдан авч, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгалаах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд ашиглаж байгаа ба үүний үр дүнд алба хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан.

8. Өмнөговь сум дахь цагдаагийн хэсгийн алба хаагчдын орон сууц барих ажлыг эхлүүлсэн.

9. Алба хаагчдын өрөө, сургалт, арга зүйн танхимд шинэ тавилга, техник хэрэгсэл худалдан авч байршуулж байгаа ба үүний дагуу алба хаагчдын ажиллах орчин сайжирсан зэрэг ажил арга хэмжээг хэрэгжүүлсэн.

#### *1.6. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээний талаар:*

Тус аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Улаангом сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт хүсэлт уламжилж энэ оны эхний улиралд дараах хөрөнгийн шинжтэй асуудлуудыг шийдвэрлүүлсэн. Үүнд:

1. Цагдаагийн газарт “Теле студи” байгуулахад шаардагдах 16 сая төгрөг,
2. Цагдаагийн газрын телекамерын 2020 оны засвар үйлчилгээнд зорилуж 9 сая төгрөг,
3. Улаангом сумын 7 дугаар багийг камержуулахад шаардагдах 40 сая төгрөг,
4. Улаангом сумын 5 дугаар багийг камержуулахад шаардагдах 50 сая төгрөг,
5. Аймгийн Засаг даргаар уламжлуулан цагдаагийн газрын барилгын их засварт шаардагдах 400 сая төгрөг, автомашин, техник тоног төхөөрөмж авахад шаардагдах 278 сая төгрөг,
6. Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Улаангом сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн даргын шийдвэрээр суудлын автомашин худалдан авахад 9 сая төгрөг,
7. Өмнөговь сум дахь цагдаагийн хэсгийн алба хаагчдын орон сууц барихад зорилуж 25 сая төгрөг, нийт 827000000 /найман зуун хорин долоон сая/ төгрөгийн мөнгөн хөрөнгийг шийдвэрлүүлж, холбогдох худалдан авах ажлуудыг эхлүүлсэн.

#### *1.7. Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хугацаа, үр дүн*

Тус цагдаагийн газрын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас энэ оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр одоогоор байхгүй болно.

#### *1.8. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ*

Цагдаагийн газрын хэмжээнд Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг Захиргааны удирдлагын тасгийн дарга, хүний нөөцийн мэргэжилтэн, Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах тасгийн дарга, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Замын цагдаагийн тасгийн дарга, Эдийн засгийн мөрдөгч нар байхаар цагдаагийн газрын даргын тушаалаар томилсон.

Салбар зөвлөл нь Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон тэдгээртэй холбоотой бусад хууль тогтоомж, шийдвэрийг цагдаагийн газрын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Тус аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2020 оны ажлын төлөвлөгөөний төслийн саналд иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг үе шаттай явуулах саналыг хүргүүлэн тусгуулсан.

Мөн тус цагдаагийн газрын 1 дүгээр давхарт буюу “Иргэдийн танихм”-д Авлигын эсрэг хууль, хөтөлбөр болон тус цагдаагийн газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээг сурталчилах булан, самбар гаргаж холбогдох мэдээлийг байршуулан иргэд олон нийтэд сурталчилсан.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20 дугаар тогтоолын хавсралтанд заагдсан Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын 2019 оны ХОСХОМ-ийг <https://meduuleg.iaac.mn> цахим системд бүрэн оруулж баталгаажуулсан. Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, тэдгээртэй холбоотой бусад хууль тогтоомж, шийдвэрийг алба хаагчдад таниулах, авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан Үүнд:

-Тасаг, хэсгийн алба хаагчдын дунд Авлигаас ангид байх амлалтын дэвтэр аялуулж, авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ХАСХОМ-ыг үнэн зөв, хугацаанд нь мэдүүлэх талаар бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 1 удаа 1 цагийн сургалт зохион байгуулсан ба нийт 125 алба хаагч хамрагдсан.

-Алба хаагчдад “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн танилцуулга, шаардлага хэрэгцээ, ач холбогдолын талаар мэдээлэл хийсэн.

-Цагдаагийн ЭБАТ цагдаагийн ахмад Б.Энхсаруул Авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчилж, ХАСХОМ мэдүүлэх зөвлөмж, аргачлалыг алба хаагчдад өгсөн.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас иргэдэд зориулсан “Авлига, хээл хахууль хүнд сурталын эсрэг вакцин”, “Эрүүл авлигагүй, хээл хахуульгүй нийгмийн төлөө хамтдаа” “Шударга нийгмийн төлөө хамтдаа”, “Авлига- Боловсролын эсрэг гэмт хэрэг”, “Авлига-Хүний эрхийн эсрэг гэмт хэрэг”, Авлига-Хөгжил дэвшлийн эсрэг гэмт хэрэг”, Авлига- Байгаль орчны эсрэг гэмт хэрэг” зэрэг зурагт хуудас болон мэдүүлэг гаргагч нарт зориулсан 3 төрлийн зурагт хуудас, Баадай болон түүний гэр бүлийн ашиг сонирхлын зөрчил, авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, “Мэдүүлэг гаргагчид зориулсан гарын авлага”, “Ашиг сонирхлын зөрчлийн мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага” зэрэг ном, зурагт хуудас, боршур зэргийг алба хаагч болон иргэд олон нийтэд түгээж, цагдаагийн газрын 1, 2 дугаар давхар болон алба хаагчдын өрөөнүүдэд зурагт хуудсуудыг байршуулсан.

Үүний үр дүнд алба хаагчид Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлал, ач холбогдлын талаар мэдлэг, мэдээлэлтэй болж, авлига, ашиг сонирхолтой холбоотой ямар нэг хэрэг, зөрчилд энэ оны эхний улирлын байдлаар алба хаагч холбогдоогүй эерэг үр дүн гарсан.

*1.9. Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар:*

Иргэд, байгууллагаас энэ оны эхний улирлын байдлаар цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчидтай холбоотой 6 гомдол, мэдээллийг ирүүлсэн ба нийт 15 алба хаагч холбогдсон байна.

Үүнээс хууль ёс хүний эрх чөлөө зөрчсөн 1, ЦАХ-ын харилцааны соёл, ёс зүй зөрчсөн 2, архидан согтуурсан 1, ЭХХШТХ болон бусад хууль тогтоомж зөрчсөн талаарх гомдол 2 байна.

Тухайн гомдол мэдээлэл бүрийг хүлээн авч бүртгэлд оруулж, холбогдох албан тушаалтан албаны шалгалт явуулж, 1 алба хаагчид цагдаагийн цол бууруулах, 1 алба хаагчид “Сануулах” сахилгын шийтгэл оногдуулж, 13 алба хаагчид холбогдох гомдол нотлогдоогүй үндэслэлээр тус тус хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн гомдол гаргагчид хариуг 100 хувь бичгээр өгч ажилласан.

Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүрийн 25-ны дотор ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

#### *1.10. Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ*

Тус цагдаагийн газраас энэ оны эхний улиралд зөрчлийн 1 хэрэгт 1 алба хаагч холбогдсон байх ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зөрчлийн хэргийн тоо болон холбогдсон алба хаагчийн тоо ижил түвшинд байна.

Алба хаагчдаас мөн хугацаанд сахилгын 3 зөрчилд 3 алба хаагч холбогдож, сахилгын арга хэмжээ авагджээ.

Зөрчил гаргасан алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзвэл хэсгийн төлөөлөгч 1, хэсгийн байцаагч 1, гэрээт цагдаа 1 байна.

Сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын 2 буюу 66.6 хувь нь офицер, 1 буюу 33.3 хувь нь ахлагч алба хаагч эзэлж байна.

Сахилгын зөрчлийн 1 буюу 33.3 хувийг дотоод хяналтаар, 2 буюу 66.6 хувийг иргэд байгууллагын гомдол болон төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичгээр тус тус илрүүлсэн.

Сахилга ёс зүйн зөрчлийг урд оны мөн үетэй харьцуулахад зөрчил болон холбогдсон алба хаагчдын тоо ижил түвшинд байна.

Сахилгын зөрчлийг хэлбэрээр нь авч үзвэл архидан согтуурсан 2 буюу 66.6 хувийг, Зөрчлийн тухай хууль тогтоомж зөрчсөн 1 буюу 33.3 хувийг эзэлж байна.

Цагдаагийн газрын алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг судлахад зөрчил гарахад нөлөөлсөн дараах шалтгаан нөхцлүүд байна гэж үзлээ. Үүнд:

1. Алба хаагчид согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэх явдал нь гэмт хэрэг, зөрчил болон сахилга ёс зүйн зөрчил үйлдэх гол шалтгааны нэг болж байна.

2. Алба хаагчид өөрсдөө бие дааж мэдлэг ур чадвараа дээшлүүлдэггүй.

3. Хувь хүний төлөвшил, хандлага, мэргэжлийн ур чадвараас шалтгаалан сахилга ёс зүйн зөрчил гаргаж байна.

Цагдаагийн газрын алба хаагчдыг сахилга ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ажлын хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн дараах ажил арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

- Алба хаагчдаас 2019 онд гаргасан сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, тасгийн дарга нарт зөвлөмж хүргүүлсэн.

- “Өнгө нэмцээ” аяны хүрээнд Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг ханах албанаас “Нэг сэтгэл нэг соёл” уриан дор зохион байгуулсан



арга хэмжээний төлөвлөгөөний дагуу алба хаагчдын сахилга ёс зүйд чиглэсэн ажил арга хэмжээг 2 сарын турш тасралтгүй зохион байгуулсан.

- Тээврийн цагдаагийн албанаас зохионб айгуулж байгаа “Хорт зуршил-Эрүүл бие” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу алба хаагчдын сахилга ёс зүйд чиглэсэн ажил, арга хэмжээг долоо хоног бүр тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна.

- Энэ оны 1 дүгээр улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн” зохион байгуулсан.

- Алба хаагчдаас бичгээр баталгаа 1 удаа гаргуулан авсан
- Сахилга ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр сар бүр соён гэгээрүүлэх ажил, сургалтыг зохион байгуулж, байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хаягт байршуулсан.

- Цагдаагийн газрын дарга, тасгийн дарга нараас алба хаагчдад сахилга ёс зүйн чиглэлээр ажлын чиглэл, зааварчилгыг бичгээр 1 удаа өгсөн

- Дээд шатны байгууллагаас ирүүлсэн сахилга ёс зүйтэй холбоотой үүрэг, ажлын чиглэлийг алба хаагчдад тухай бүр танилцуулсан зэрэг ажил арга хэмжээг зохион байгуулсан.

#### *1.11. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:*

Тус цагдаагийн газар нь 2020 оны 1 дүгээр улиралд улсын төсвөөс 641257,2 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 16142.7 мянган төгрөг тус тус батлагдаж, гүйцэтгэлээр 641257,2 мянган төгрөгийн санхүүжилт авч, байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 114 %-иар давуулан биелүүлж 18542.9 мянган төгрөгийг дансанд төвлөрүүлж сар, улирлын хуваарийн дагуу алба хаагчдын цалин хөлс болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах тогтмол зардал, хангамж бараа материалын бусад зардлуудыг зардлын бүлэг тус бүрээр хянаж гүйлгээ хийж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, авлага, өглөгийн мэдээг сар бүр гаргаж хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Мөн нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын захирамжаар аймгийн хөрөнгө оруулалтаар цагдаагийн газрын төв конторын их засварын зураг төсвийн зардал 9680,0 мянган төгрөг, камерын засвар үйлчилгээ, тоног төхөрөөмжийн зардал 17500,0 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар автомашин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тавилга худалдан авах 286650,0 мянган төгрөг, иргэдийн галт зэвсгийн төлбөртэй сургалтын төлбөр 150,0 мянган төгрөг, аймгийн гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 1128,0 мянган төгрөг, нийт 315108,0 мянган төгрөг орсоньг бүртгэж, холбогдох баримт бүрдүүлж аймгийн СТСХ-т хүргүүлж зарцуулах эрх нээлгэж ажилласан.

Энэ оны 1 дүгээр улиралд автомашин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тавилга худалдан авах 286650,0 мянган төгрөг, камерын засвар үйлчилгээ, тоног төхөрөөмжийн зардал 25000,0 мянган төгрөг, тээвэр шатахууны 108610,8 мянган төгрөг тус тус нээлттэй цахим тендер заралж, сонгон шалгаруулалт явуулж шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ажиллахын зэрэгцээ бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, барилгын жижиг засварын материал нийлүүлэх үнийн санал авч харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явууллаа. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус цагдаагийн газрын төв конторын барилгын их засварын зардал 400,0 сая төгрөг батлагдсаны дагуу аймгийн ОНӨГ нээлттэй тендер зарлаад байна.

Мөн Төрийн өмчийн удирдлага мэдээллийн цахим ситемд 2019 оны үндсэн хөрөнгийн хөдөлгөөн шивж, ТӨХ, ТӨ тайлангуудыг гаргаж санхүүгийн тайлангийн хамт Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгч баталгаажууллаа.

Шилэн дансны нэгдсэн системд тус цагдаагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Аудитын байгууллагын дүгнэлт, 2020 оны 1-3 дугаар саруудын төсвийн орлого, зарлагын гүйлгээ, тендер, худалдан авалт, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан болон тодотгосон төсөв, бүтэц орон тоо, өглөг, авлагын талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон цагдаагийн газрын цахим хуудсанд тус тус байршуулж, 1 дүгээр улирлын тайланг цахимаар илгээж ажилласан.

ЦЕГ-ын ХШДАХ болон Санхүү, аж ахуйн албанаас ирүүлсэн шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлж, байгууллагын санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбарт сар бүр тогтмол мэдээлэл байршуулах ажлыг хэвшүүлээд байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх “Иргэний зөвлөл”-д 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг танилцуулж, “Шилэн данс” мэдээллийн самбараар байршуулан ажиллалаа.

### *1.12. Зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ:*

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн шинэ санал, санаачлагыг дэмжих /код 116/ журам”-ыг хэрэгжилтийг хангах, цагдаагийн газрын алба хаагчдаас санаачилсан шинэ санал санаачлага, шинэлэг ажлыг дэмжин ажиллаж байна.

Энэ оны эхний 1 дүгээр улиралд тус цагдаагийн газар нь дараах шинэлэг ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

➤ Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хулгай ба гэр хорооллын хяналт 2020” арга хэмжээг зохион байгуулсан.

➤ Олон нийтийн цагдаагийн ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Олон нийтийн цагдаагийн ажилтны сургалт-зөвлөгөөн”-ийг цахим хэлбэрээр зохион байгуулсан

➤ Алба хаагч нэг бүрийн гэрээр зочилж, гэр бүлээс нь санал асуулга авч, ахуй амьдарлтай нь танилцсан.

➤ Дэлхий нийтэд тархсан шинэ төрлийн корона вирус /COVID/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн газрын эмэгтэй алба хаагчид 2 төрлийн амны хаалт хийж /амны хаалт дээр “Өнгө нэмье” гэсэн бичглэл хийж/ алба хаагчдад тараасан зэрэг шинэлэг ажил, арга хэмжээг зохион байгуулсан.

**Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:**

### *2.1. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:*

Энэ оны эхний улиралд Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчид иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид 209,016,400 төгрөгний хохирол учруулсан 36 холбогдогчтой, 25 хэрэг, үйлдэл илрүүлсэн шалгасан байна.

Илрүүлсэн онцлог хэргүүдээс дурьдвал:

1. Тус аймгийн Улаангом сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах иргэн С.Дорждэрэмийн агуулахаас 2019 оны 12 сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 сарын 02-ны өдрийн хооронд 425 ширхэг ямааны арьс хулгайлагдсан хэрэг бүртгэлтийн

203500010 дугаартай хэрэг, 2020 оны 02 дугаар сарын 29-ны өдөр Улаангом сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт иргэн Э.Болортуяаг дээрэмдсэн хэрэг бүртгэлтийн 203500059 дугаартай хэргүүдийг тус сумын харъяат Ч.Давааням, О.Нямдорж, Г.Ганбат нарын 7 этгээд бүлэглэн үйлдсэн болохыг илрүүлсэн.

2. Сагил сумын Засаг дарга Д.Дэлгэрхишиг, Засаг даргын орлог У.Цэцэгбал нар албан тушаалын эрх мэдлээ урвуулан 45,000,000 төгрөг хувьдаа завшсан үйлдлийг илрүүлэн хэрэг бүртгэлтийн 203500030 дугаартай хэрэг нээн шалгаж Авилгатай тэмцэх газарт шилжүүлсэн.

3. Хяргас сумын Засаг дарга Ц.Цэвээнравдан албан тушаалын эрх мэдлээ урвуулан 17,500,000 төгрөг хувьдаа завшсан үйлдлийг илрүүлэн хэрэг бүртгэлтийн 203500040 дугаартай хэрэг нээж шалгаж Авилгатай тэмцэх газарт шилжүүлсэн.

Тус цагдаагийн газрын эрүүгийн мөрдөгчид нь энэ онд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 133 гомдол, мэдээлэл хүлээн авч 21 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 17 гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 5 гомдол, мэдээллийг харъяаллыг дагуу шилжүүлж, 82 гомдол, мэдээлэлд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авч шийдвэрлэсэн гомдол гаргагчид 100 хувь хариуг өгч ажилласан.

Зөрчил гаргасан 55 иргэнд 7,235,000 төгрөгний торгууль оногдуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 13 иргэний жолоодох эрхийг 1 жилийн хугацаатайгаар хасаж, 14 иргэнийг шүүхээр 7-30 хоногийн хугацаатай баривчлуулсан байна.

2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар тус Цагдаагийн газраас эрэн сурвалжлах "ASAP" сан ашиглалтанд орсноос хойш нийт 849 хүн, мал, эд зүйлийн мэдээллийг санд оруулан эрэн сурвалжилж 732 хүн, мал, эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

"ASAP" сангаар эрэн сурвалжлагдаж байсан гэмт хэрэгт сэрдэгдсэн 25, оргодол 2, оршин суугаа газраасаа алга болсон 4, шүүхээс даалгасан 2 хүн, тээврийн хэрэгсэл 2 тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон.

Мөн улсын хэмжээнд зохион байгуулсан "Сар шинэ" нэгдсэн арга хэмжээний хүрээнд ЭЦА-ны Эрэн сурвалжлах хэлтсээс ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн дагуу эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Гантулга, цагдаагийн ахлах дэслэгч Р.Чимэд-Очир нарыг Улаанбаатар хотод 20 хоног томилолтоор ажиллуулж эрэн сурвалжлагдаж байсан оргодол 1, гэмт хэрэгт сэрдэгдсэн 8, нийт 9 этгээдийг олж баривчилж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч хэргийг нь шийдвэрлүүлсэн байна.

## *2.2.Мөрдөн байцаах албаны чиглэлээр:*

Мөрдөн байцаах тасаг нь энэ оны эхний 1 дүгээр улирлын байдлаар гэмт хэргийн шинжтэй 21 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 20 гомдол мэдээлэл буюу шалгасан нийт гомдол мэдээллийн 95.2 хувийг шийдвэрлэсэн ба үүнээс 14 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 6 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзажээ.

Мөн хугацаанд хэрэг бүртгэлтийн 42 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 2 хэргийг харъяаллын дагуу шилжүүлэх саналтай, 30 хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсэн ба одоо 10 хэргийн үлдэгдэлтэй.

Энэ оны эхний улиралд шинээр эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан болон бусад газраас хүлээн авсан нийт 30 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 29 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж шийдвэрлэсэн.

Нийт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргийнхээ 96.6 хувийг шийдвэрлэсэн байх ба шийдвэрлэсэн хэргийнхээ 95 хувийг хуульд заасан анхны хугацаанд барагдуулсан байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гэмт хэргийн улмаас 75,4 сая төгрөгний хохирол аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд учирснаас 75,1 сая төгрөгний хохирлыг буюу 99.6 хувийг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба нийт 37 сая төгрөгний эд хөрөнгийг битүүмжлэн хөрөнгө хамгаалах арга хэмжээ авсан.

Мөрдөн байцаах албанаас Монгол банк, Монголын банкуудын холбоотой хамтран 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатай улсын хэмжээнд зохион байгуулсан “Ятгах тусам нягтал” аяны хүрээнд Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэнүүдтэй хамтран “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, залилах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг нийт 96 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид зохион байгуулсан ба сургалтанд 892 хүн хамрагдсан.

Мөрдөн байцаах албанаас орон нутгийн нэгжүүдэд хүргүүлсэн богино хэмжээний дүрст бичлэг, шторк, зурагт хуудас, мөн өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан бэлдсэн 3 төрлийн санамж сэрэмжлүүлэг, 4 төрлийн өнгөт зурагт хуудас бүхий сурталчилгааны материал, лого зэргийг арилжааны Хаан, Голомт, Төрийн банкны бэлэн мөнгөний АТМ машинууд болон “Улаангом”, “Дэлгэрэх”, “Шөнийн зах” зэрэг иргэд олноор үйлчлүүлдэг худалдаа үйлчилгээний томоохон төвүүдэд тараан байршуулан ажилласан.

### *2.3. Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:*

Энэ оны 01 дүгээр улирлын байдлаар иргэдээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлгийн 11.1 дүгээр зүйлийн 2.5 дахь хэсэгт зааснаас бусад энэ бүлэгт заасан гэмт хэргийн талаарх 37 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаж 33 гомдлыг шийдвэрлэсэн ба одоо үлдэгдэл 4 гомдол шалгагдаж байна.

Хэрэг бүртгэлтийн 21 /урьд оны дугаартай 6/ хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 4 хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлж, 15 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, одоо ажиллагаанд хэрэг бүртгэлтийн 2 хэрэг шалгагдаж байна.

Мөрдөн байцаалтын нийт 22 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хэргийг шүүхэд шилжүүлэх 100 хувь шийдвэрлэсэн.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Сар шинэ-2020”, “Архигүй орчин” арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн видео бичлэг, контентуудыг “Увс аймаг дахь цагдаагийн газар” facebook хаяг, “Увс аймгийн нэгдсэн групп”, “Элхэн нутаг Увс”, “Увс миний нутаг”, “Бид увсынхан”, “Увс аймгийн зарын нэгдсэн групп” зэрэг 373100 хандагчтай 19 цахим хуудаст байршуулж иргэдэд сурталчилж, Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, баривчлах байранд шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан болон харьяаллын хэрэгт гадуур шалгагдаж байсан 57 иргэнд 5 удаагийн 7 цагийн сургалт зохион байгуулж, Цагдаагийн байгууллагаас нэгдсэн арга хэмжээ, аяны хүрээнд бэлтгэж гаргасан 21 төрлийн контент, шторкыг үзүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлсэн.

ЦЕГ-ын Хэрэг бүртгэх алба, Урьдчилан сэргийлэх хэлтсийн пейж хаягт байршуулсан урьдчилан сэргийлэх мэдээллүүдийг татан авч Монгол улсын баатар Б.Гивааны талбайд байрлах лед дэлгэц, орон нутгийн телевизүүдээр сурталчилж

иргэд олон нийтэд мэдээлэл хүргэж, 600 ширхэг гарын авлага, санамж сэрэмжлүүлэг, зурагт хуудас бэлтгэн иргэдэд тараан өгч, орон нутгийн 2 телевизэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаа мэдээлэл хийж, 1 удаа “Зочны цаг” шууд нэвтрүүлэгт оролцсон.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 284 этгээдийг хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтран хяналтад авч, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх чиглэлээр баталгаа авч, бусад иргэдэд урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэх ажлыг уг иргэдтэй хамтран зохион байгуулан ажилласны үр дүнд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг энэ оны 1 дүгээр улирлын байдлаар 5 нэгжээр буюу 23.8 хувиар буурч, илрүүлэлт 17.6 хувиар өссөн байна.

#### *2.4. Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:*

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар Увс аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээр 158 , Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр 3, эрүүгийн хэргийн шүүхээр 92, захиргааны зөрчлийн 61 шүүх хурал нийт 314 шүүх хурлын хамгаалалтанд хамгаалалтын 2 цагдаа үүрэг гүйцэтгэж шүүх шүүгчийн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг ханган шүүх хуралдааны танхимд холбогдогч, шүүгдэгч нарыг үзлэг шалгалт хийж шүүн таслах ажиллагаа явуулах хэвийн нөхцлийг бүрдүүлэн шүүх хуралдааны дэгийг сахиулж ажилласан .

Шүүхийн байрнаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байр хүртэл Цагдаагийн газрын жижүүрийн албаны автомашинтайгаар хуяглан хүргэх ажиллагааг ердийн болон хүч нэмэгдүүлэн зохион байгуулсан.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид 2020 оны 1-р улиралд Увс аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Увс аймгийн Давж заалдах шатны шүүхээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байранд 28 удаагийн хуяглан хүргэлтээр 28 шүүгдэгч, яллагдагч, ялтанг хүлээлгэн өгсөн. Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс албадан ирүүлэхээр даалгасан шүүгчийн захирамжаар 1 иргэнийг хүлээлгэн өгсөн.

Үйл ажиллагааны журмын дагуу хуяглан хүргэх ажиллагааны өмнө шүүгдэгч, яллагдагч, ялтныг хүлээн авахдаа шүүх хуралдааны тов, шүүхэд дуудах хуудасны дагуу овог, нэрээр тулгалт хийж хүлээн авч, хувцас болон бие, эд зүйлд үзлэг хийж, хориотой эд зүйл байгаа эсэхийг үзэж шалган, шүүх хуралдааны журам сахиулагч, цагдан хорих байрны жижүүртэй шүүгдэгч, яллагдагч, ялтныг бүртгэлээр хүлээлцэж, түр саатуулах байранд байрлуулах, автомашинаар хуяглан хүргэх явцдаа нэг бүрийн тусгай хэрэгсэл гав хэрэглэж байна. Мөн цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан шүүгдэгч, ялтанд амны хаалт зүүлгэж, гар ариутгах бодисоор гарыг нь ариутгуулан ажиллаж байна.

Увс аймаг дахь иргэн, эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Увс аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн байрны аюулгүй байдлыг ханган учирч болох гэмт халдлагаас урьдчилан сэргийлэн харуулын цагдаа нар 90 удаа, 2160 цагийн үүрэг гүйцэтгэж, 775 иргэний баримт бичиг холбогдох эд зүйлд үзлэг шалгалт хийж, шүүхийн байранд нэвтрүүлэн аюулгүй байдлыг ханган, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан амны хаалттай үйлчлүүлэх шаардлага тавьж амны хаалтгүй иргэдийг нэвтрүүлэхгүй ажилласан.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд хөтлөгдвөл зохих бичиг баримт маягт бүртгэл судалгааг хууль, журмын дагуу шинэчлэн боловсруулж бүрэн хөтөлж

эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан хүмүүсийн фото зураг, гарын хээний дардсыг Папилон санд бүртгэлийг нэгдсэн санд оруулж, АСАР сангаас оргодол этгээд болон эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийн сэжигтэнг олж илрүүлэхэд ашиглан ажиллаж байна.

Эрүүлжүүлэх саатуулах байранд энэ оны 1 дүгээр улиралд саатуулагдсан 3, эрүүлжүүлэгдсэн 243 хүнээс Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2007 оны 58/62 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан эрүүлжүүлэх үйлчилгээний хөлс авах журмын дагуу 243 хүний 1 008 450 төгрөгний төлбөрийг 100 хувь хураан авч төрийн сангийн 150012001 тоот дансанд тушааж санхүүтэй тооцоо хийсэн.

Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан 70 иргэнийг хүлээн авснаас 62 иргэний 687 ор хоногийн 2.677.127 төгрөгийг хураан авч 150012001 тоот дансанд төвлөрүүлсэн. Одоо биеээр эдлэж байгаа болон төлбар төлөөгүй 8 хүний 120 ор хоногийн 419.627 төгрөгний төлбөр төлөгдөөгүй байна. Эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан хүн нэг бүрт эрүүл мэндийн үзлэг хийж 29 хүнд хордлого тайлах, зүрхний хэм алдагдлыг бууруулах, артерийн даралт буулгах, цус тогтоох, өвчин намдаах эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж эмчлүүлэх боломжоор хангаж, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн ба энэ тухай эмчийн үзлэгийн бүртгэлийн дэвтэрт болон картанд тухай бүр тэмдэглэл хийж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн биеэ авч явах чадваргүй 65 иргэнийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн.

Баривчлагдсан иргэдэд сургалт зохион байгуулах Цагдаагийн газар Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан иргэдэд архи, тамхины хор хөнөөл, архинаас татгалзах арга зам, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын талаар ГБХХГХУС мэргэжилтэн, Сэтгэл зүйч, Хэсгийн байцаагч, ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд сургалт, мэдээлэл зохион байгуулж өрөө тус бүрт байршуулсан өсгөгч, чанга яригчаар сэрэмжлүүлэг, шторкыг тодорхой цагуудад тогтмол явуулж, нийт 70 хүнийг 742 цагийн албадан сургалтанд хамруулсан.

Баривчлагдсан хүн нэг бүрт хувийн хэрэг нээж, гарын хээний дардас авч, фото зургийг материалд хавсаргаж, хууль эрх зүйн зөвлөгөө өгч, шийтгэлийн хугацаа дуусч баривчлах байрнаас гарах үед тойрох хуудас зуруулж, баривчлах байрны шууд зардлын тооцоог хийлгүүлсэн. Нэг хүнд ногдох хоногийн хоолны илчлэг 2800 к/кл-аар тооцож тогтоосон нормын дагуу материалыг авч, өдөрт 2 удаа халуун хоол, 2 удаа буцалсан ус, хүйтэн цай, талхаар үйлчилж телевиз, ном сонин, шатар, даам зэрэг чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, угаалгын машинд хувцас цэвэрлэх, усанд орох, 14 хоногт цагаан хэрэглэлийг 1 удаа ариутгаж, ар гэрээс эргэлт авах, ар гэртэйгээ утсаар ярих зэрэг нөхцөл боломжоор хангаж ажилласан.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч, цагдаа нар эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан иргэдийн мэдээллийг нэгдсэн санд шивж АСАР сантай тулгалт хийж, ЦБҮАЖ код 307-д заасны дагуу 2 алба хаагч гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг, эрэн сурвалжлагдаж байсан 3 иргэнийг мөн болохыг тогтоож холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч илтгэх хуудсаар танилцуулсан.

Эрүүлжүүлэх, баривчлах байранд 7 хоногт 2 удаа их цэвэрлэгээ хийж, өдөр бүр жевалион уусмалаар ариутгаж, хучлага хөнжилд ариутгал халдваргүйтгэлийг өдөр бүр хийж, цагдаагийн газартай гэрээ байгуулсан “АРИУСАХУЙ” ЗБН байгууллагаар цагдаагийн газрын байрны өрөө тасалгаанд ариутгал хийлгэсэн. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан халдварт “Коронавирус”-аас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Зооноз өвчин судлалын төвтэй хамтран цагдаагийн

газрын алба хаагч бүрийн өрөө, тасалгаа, автомашины граж, дотор болон гадна орчинд ариутгал хийлгэж ажилласан.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд заасны дагуу согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ гэр бүлийнхээ болон бусдын амгалан тайван байдал алдагдуулж, гудамж талбай, олон нийтийн газар архидан согтуурдаг гэмт хэрэг, зөрчилд холбогдож, эрүүлжүүлэх байранд удаа дараа давтан эрүүлжүүлэгдсэн архины хамааралтай 5 иргэнийг Аймгийн нэгдсэн эмнэлгийн цахим санд бүртгүүлж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулж сэтгэц наркологийн их эмчээр архинд донтох өвчтэй эсэх дүгнэлтийг гаргуулж архинаас гаргах албадан эмчилгээнд явуулахаар ажиллаж байна.

Аймаг, орон нутгийн онцлог, гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэрэг эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд тулгуурлан 2020 оны эргүүлийн нэгдсэн байршилтыг улирлын байдалт тохируулан боловсруулж, тухайн үеийн нөхцөл байдалтай холбогдуулан эргүүлийг өдөр, орой, шөнийн цагийн хуваарийн дагуу явган болон автомашинтайгаар давхардсан тоогоор 787 алба хаагч, олон нийтийн цагдаа эргүүлд давхардсан тоогоор 157 удаа үүрэг гүйцэтгэсэн. 2020 оны 1-р улиралд халдварт коронавирус гарсантай холбогдуулан монголын уламжлалт “Сар шинэ-ийн баярын өдрүүдэд давхардсан тоогоор нэмэлтээр цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Хилийн цэргийн -0245 дугаар ангийн 491 алба хаагч хяналт тавьж эргүүл хяналт хийж ажилласан.

Эргүүлд 12 цагдаа үүрэг гүйцэтгэж 5760/720 хүн цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, эргүүлийн үр дүнд 204 зөрчил илрүүлж ажиллаж, иргэд, байгууллагаас ирүүлсэн 312 гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл дуудлаганд ажиллаж, 52 хүнийг саатуулах байранд, 309 хүнийг ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 21 жолооч илрүүлж, хэв журмын хамгаалтанд 24 удаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 5 удаа, хэргийн газрын хамгаалалтанд 3 удаа ажилласан.

Цагдаагийн газраас Монгол банкны Увс аймаг дахь салбартай 2019 онд хамтран ажиллах гэрээг дүгнэж 2020 онд хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, харуулд ажиллах 4 алба хаагчийн үйл ажиллагааны зардал, төсвийг хүргүүлж ажилласан.

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, гэрээт цагдаа нарын ээлж хүлээлцүүлж галт зэвсгийг шалгах, хүлээлцэх, хоногийн нөхцөл байдлын илтгэх хуудастай өдөр бүр танилцаж хяналт тавьж, удирдлагаар хангаж ажилласан.

Энэ оны 1 дүгээр улиралд Монгол банкны салбарт жижүүрийн цагдаа нар 90 удаа, 2160 цагийн үүрэг гүйцэтгэж, 220 иргэний бичиг баримт, эд зүйлийг шалган нэвтрүүлж, ХААН банк 40, Хас банк 23, Төрийн банк-35, Голомт банк 27 удаа зузаатгал авах үед хамгаалалт зохион байгуулсан. Монгол банкны төв салбараас 1-р улиралд зузаатгал ирээгүй болно.

Банкны байрны аюулгүй байдал дохиолол, хяналтын камер, утаа мэдрэгч зэргийг өдөр бүр тухайн өдрийн ёс журам сахиулах эргүүл, ерөнхий жижүүр хамт шалгаж бичгээр үүрэг чиглэл өгсөн.

Гэрээт болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 3 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас нэг харуул хамгаалалтын албаны тусгай зөвшөөрөл дууссан тул холбогдох хууль, журмын хүрээнд үйл ажиллаа явуулах эрх сунгах хүсэлтийг гаргасан тул үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 1 жилээр сунгаж SAS програмд 3 хамгаалалтын алба байгууллагын мэдээлэлийг бүрэн шивж бүртгэлийн дугаар авч үйл ажиллагаа явуулж байна.

Тус аймагт нийт 17 олон нийтийн цагдаа ажиллаж байгаа ба энэ оны 1 дүгээр

улиралд олон нийтийн цагдааг чадавхижуулах нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр 1 удаа Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан.

#### 2.5. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиглэлээр:

Увс аймгийн цагдаагийн газраас 2020 онд олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Увс аймгийн төв, сумдын нутаг дэвсгэрийг бүслэн хаах төлөвлөгөө, Онцгой нөхцөл байдал үүссэн үед Хил хамгаалах, Тагнуул, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран ажиллах төлөвлөгөө, Гал түймэр гарсан үед байгууллагыг авран хамгаалах, Тэсэрч дэлбэрэх бодис, химийн хорт бодистой холбоотой дуудлага мэдээлэл ирсэн үед ажиллах, Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах, Гамшгийн нөхцөл байдал үүссэн, онц байдал зарласан үед ажиллах төлөвлөгөө, зураглалыг шинээр хийж батлуулж нэг хувийг ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд хүргүүлсэн.

Эхний улирлын байдлаар дэлхийн нийтэд тархаад байгаа шинэ төрлийн коронавирусийн тархалттай холбоотойгоор нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно.

Шинэ төрлийн коронавирус /COVID-19/ гарсантай холбоотойгоор дараах арга хэмжээ хамгаалалтыг зохион байгуулж ажилласан . Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах, Улсын Онцгой комиссын шийдвэр, аймгийн онцгой комиссын шийдвэр, Цагдаагийн ерөнхий газар, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас өгсөн үүрэг, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлж, цагдаагийн газрын бэлэн байдлыг хангуулж дэлхийн улс орнуудад тархаад байгаа шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, албан үүрэг гүйцэтгэхдээ өөрийн болон албаны бэлэн байдлыг хангаж ажиллах талаар алба хаагч нарт сургалт зохион байгуулсан.

2. Улс, аймгийн онцгой комиссоос гарсан шийдвэр, Цагдаагийн ерөнхий газар, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас өгсөн үүрэг, чиглэлийн хүрээнд Увс аймгийн төв, сумдыг бүслэн хаах батлагдсан төлөвлөгөөний дагуу аймаг, сумын хөдөлгөөнд хяналт тавих пост гаргаж ажилласан.

Үүнд: Аймгийн төвд 8 пост, 18 суманд 46 постыг 24 цагаар ажлуулж давхардсан тоогоор 512 офицер, 432 цагдаа, 132 автомашинтай нийт 944 алба хаагч ажиллаж аймгийн төв болон сумд руу орж, гарсан 2991 тээврийн хэрэгсэл, 10075 хүнд хяналт тавьж, эрүү, хэв журам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Мөн тус аймагт 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс Оросын холбооны улсаас ачаа тээврийн автомашин 16 авто машин ирснийг холбогдох журмын дагуу аюулгүй ажиллагааг ханган ажилласан.

#### 2.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Тус цагдаагийн газраас ЦЕГ-ын УСХ болон бусад албадаас ирүүлсэн удирдамжийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран “Сар шинэ-2020”, нэгдсэн арга хэмжээ “Ятгах тусам-нягтал”, “Архигүй орчин”, “Хайр-өвтгөдөггүй” аянуудын хүрээнд салбар төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн үр дүнг нь тооцон ажиллаж байна.



Гэмт хэргийн гаралтын шалтгаан нөхцөлийг судлан тодорхойлсны үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Гэр хорооллын хяналт 2020”, “Урамшуулалт эргүүл 2020”, “Шатахуун түгээх станц 2020”, “Хөдөлгөөний соёл дэг журам”, “Цахим тоглоомын хяналт шалгалт”, “Хяналт 1”, “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэг хэрэгслийн бүрэн бүтэн байдал”, “Улаангомын хяналт”, “Итгэл хүлээлгэх өдөр”, “Хүчирхийлэлгүй орчин бий болгоё”, “Шинээр хэрэгжиж байгаа ГХЗУСТХ-ийг сурталчлах”, “Архины хор хөнөөл” зэрэг 12 хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

“Сар шинэ-2020” нэгдсэн арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Гэр хорооллын хяналт 2020”, “Урамшуулалт эргүүл 2020”, “Шатахуун түгээх станц 2020”, “Улаангомын хяналт”, “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэг”, “Итгэл хүлээлгэх өдөр”, “Хүчирхийлэлгүй орчин бий болгоё” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулах төлөвлөгөөг боловсруулан тус цагдаагийн газрын нийт алба хаагчдыг хамруулан гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдэд алба хаагч нарт хувиарлан өгч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд айл өрх бүрээр зочлуулан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас, санамж сэрэмжлүүлэг тараан ажилласан.

“Гэр хорооллын хяналт” тусгай арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 120 алба хаагч 1200 айл өрхөөр зочилж 2 төрлийн 1200 ширхэг санамж, сэрэмжлүүлэг иргэдэд тарааж арга хэмжээний хугацаанд аймгийн төвийн гэр хорооллыг алба хаагч нарт хувиарлан өгч иргэдтэй хамтарч ажилласнаар иргэдийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралт буурсан.

Нэгдсэн арга хэмжээний хугацаанд давхардсан тоогоор 390 чиглэлд 1498 алба хаагч эргүүлд, нийтийн эргүүлд 289, урамшуулалт эргүүлд 134 иргэн үүрэг гүйцэтгэж, 1,490.000 төгрөгийн урамшууллыг сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлүүдээс шийдвэрлүүлсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 567 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд, 567 мэдэгдэл өгч хариуг хугацаанд нь авч ажилласан.

Шинэ тутам хэрэгжиж буй Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2150 иргэнд сурталчилж, 951 байгууллага, аж ахуйн нэгжийн харуул манааг шалгаж, 1732 айл өрхөөр орж, 200 ширхэг зурагт хуудас, 3200 ширхэг санамж, сэрэмжлүүлэг нийт 3400 ширхгийг тарааж ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан 16 нэгдсэн болон тусгай арга хэмжээ, 117 өдөрлөг, аян, хэлэлцүүлэг, зөвлөгөөний явцад давхардсан тоогоор 146 алба хаагч 117 удаа 99 байгууллага, аж ахуйн нэгжийн 2500 хүнд сургалт, мэдээ мэдээлэл, яриа таниулгыг хийж, тэдгээрийн санал хүсэлтийг сонсож ажилласан. Үүнд:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийг сурталчлах, сургалт явуулах, нэг мөр хэрэгжүүлэх, Ятгах тусам нягтал аяныг сурталчлах зорилгоор тус цагдаагийн газраас аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран хууль сурталчлах ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 15-наас 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгууллаа. Үүнд:

Энэ оны 1 дүгээр сарын 20-ны өдөр тус цагдаагийн газрын алба хаагч нарт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”- сурталчлах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хувиар гаргаж нэг бүрчлэн хариуцуулан өгч шинээр хэрэгжиж байгаа ГХЗУСТХууль, залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтуудыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Тус

арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 146 алба хаагч, 19 хууль эрх зүйн ажилтан, 96 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 1400 ажилтан алба хаагч, 570 иргэн, ахлах ангийн 180 сурагч, нийт 2150 хүнд сургалт орж иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж ажилласан.

“Ятгах тусам нягтал” аяны хугацаанд Аймгийн болон харьяа 18 сумдын ГХУСАЗСЗ-үүдийн дэмжлэг туслалцаатайгаар Цагдаагийн газрын нийт алба хаагчид Улаангом сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн 65 байгууллага, 34 төрийн бус байгууллага, 130 аж ахуйн нэгжид Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил арга хэмжээг зохион байгуулан тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, алба хаагчдыг аянд нэгтгэн, аянд нэгдсэн цахим хэрэглэгчдийн фейсбүүк цахим хаягийн проймайл зургийг “Ятгах тусам нягтал” хүрээгээр солиулан ажилласан.

Тус цагдаагийн газраас аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулахаар хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 4, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1, зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 9, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 1, бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 нийт 32 ажил, арга хэмжээний саналыг хүргүүлсэн.

Энэ оны 01 дүгээр улиралд тус цагдаагийн газрын дүн шинжилгээ судалгааны баг 3 удаа гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах талаар цагдаагийн газрын даргад санал оруулан алба хаагч нарт ажлын чиглэл хүргүүлэн ажиллаж байна.

Шинэ төрлийн корона вирусийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цаг хугацааг өөрчлөх талаар аймгийн онцгой комисст санал хүргүүлснээр өдөр бүрийн 15.00 цагаас хойш архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хязгаарласан, баар, караокены үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 30-ныг хүртэл үйл ажиллагааг нь зогсоосон Аймгийн засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/62, 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/120 дугаартай Захирамжуудыг гаргуулсан.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр мөрдөн байцаалтын шатанд 19 мэдэгдэл өгч 14 хариуг хугацаанд нь авч, хэрэг бүртгэлтийн хэрэгт 17 мэдэгдэл өгч 15 хариуг хугацаанд нь авч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 567 мэдэгдэл бичиж 567 хариуг авч, нийт 603 мэдэгдэл бичиж байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлэн хяналт тавин 596 мэдэгдлийн хариуг хугацаанд нь авч биелэлтийг газар дээр нь 300 удаа шалгаж үр дүнг нь тооцсон. Одоогийн байдлаар 7 мэдэгдлийн хариу заагдсан хугацаандаа байгаа болно.

Тус цагдаагийн газар нь орон нутгийн “Увс нам бус”, “МВС” телевизүүдтэй 7 хоног бүрийн Даваа гарагт эрүү хэв, журмын нөхцөл байдлыг, Баасан гарагт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 30 удаа, давталт 30, нийт 120 минутын, ухуулга, яриа, сурталчилгааг иргэд олон нийтэд мэдээлэл хийсэн. Үүнд:

“Сар шинэ 2020” нэгдсэн арга хэмжээ, Гэр бүлийн хүчирхийлэл, “Архигүй орчин” арга хэмжээнүүдийн хүрээнд МВС телевизийн зочны цаг нэвтрүүлэгт 3 удаа орж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл хийж ажилласан.

Тус цагдаагийн газраас ЦЕГ-ын УСХ болон бусад албадаас ирүүлсэн удирдамжийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран “Сар шинэ-2020”, нэгдсэн арга

хэмжээ “Ятгах тусам-нягтал”, “Архигүй орчин”, “Хайр-өвтгөдөггүй” аянуудын хүрээнд хийгдсэн “ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс” пэйж хаяганд байршуулсан шторк, постер, зурагт хуудсыг, мөн хар тамхины эсрэг гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн видео бичлэг, контентуудыг “Увс аймаг дахь цагдаагийн газар” facebook хаяг, “Увс аймгийн нэгдсэн групп”, “Элхэн нутаг Увс”, “Увс миний нутаг”, “Бид увсынхан”, “Увс аймгийн зарын нэгдсэн групп” зэрэг 1125050 хандагчтай 84 цахим хуудаснуудад тухай бүр байршуулсан, Маршал Ю.Цэдэнбалын талбайн урд талын лед дэлгэц, Цагдаагийн газрын урсдаг самбар, орон нутгийн “МВС”, “Увс нам бус”, “Увс” телевизүүдээр тус бүр сэрэмжлүүлэг мэдээ болон Эрүүгийн хуулинд шинээр орсон “Худлаа мэдээлэл тараах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 1 шторк бэлтгэж иргэдэд олон нийтэд хүргэж ажилласан.

ЦЕГ-ын УСХ болон бусад албадаас ирүүлсэн нэгдсэн арга хэмжээ, тус цагдаагийн газраас зохион байгуулсан хэсэгчилсэн арга хэмжээ, сургалтын хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 төрлийн хууль, эрх зүйн гарын авлага, 15 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг, 12 төрлийн зурагт хуудас, нийт 7620 ширхгийг тараасан.

“Сар шинэ 2020” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24,26-ны өдрүүдийн хуралдаан, Увс аймгийн онцгой комиссын хуралдааны шийдвэрүүдэд хяналт тавих зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд сумдын ГХУСАЗСЗ-үүдтэй хамтран “Урамшуулалт эргүүл 2020” тусгай арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсан.

Тус арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 360 төрийн алба хаагчийг нийтийн эргүүлд, 134 иргэнийг урамшуулалт эргүүлд үүрэг гүйцэтгүүлэн гудамж талбай, гэр хорооллуудад хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан. Эргүүлд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч, иргэд 612 айл өрхөөр зочилж хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 4 төрлийн 1133 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, корона вирусаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан төрийн шийдвэр, захирамж, уриалгыг иргэдэд тарааж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 18 ширхэг “Мэдэгдэл” бэлтгэж 321 байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тарааж харуул, манаа камержуулалтыг нь шалгаж ажилласан. Хэсгийн алба хаагч нар сумдын ГХУСАЗСЗ-д санал хүргүүлснээр 134 иргэнд 1.490.000 /нэг сая дөрвөн зуун ерэн мянган/ төгрөгийн урамшууллыг шийдвэрлүүлсэн.

Шинээр хэрэгжиж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.1.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна гэсэн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран зохион байгуулсан “Гэмт хэрэг, зөрчилгүй байгууллага хамт олныг шалгаруулах болзолт уралдаан”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан шилдэг алба хаагч шалгаруулах болзолт” уралдаануудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн “ЖЕМ” трейд ХХК-ний Увс аймаг дахь салбарын захирал Дорлиг овогтой Дамжин, Адаргана халх ХХК-ний захирал Отгонбаяр овогтой Уртнасан нарыг аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр тус тус шагнаж урамшуулсан.

Тус цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд тасралтгүй зохион байгуулсны үр дүнд гэмт хэргийн гаралт 20 нэгжээр буюу 30.8 хувиар, үүнээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 1 нэгжээр буюу 100 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг

гэмт хэрэг 5 нэгжээр буюу 23.8 хувиар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 6 нэгжээр буюу 66.7 хувиар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 9 нэгжээр буюу 33.3 хувиар, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 1 нэгжээр буюу 5.3 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 5 нэгжээр буюу 71.4 хувиар, орон сууцанл үйлдэгдсэн гэмт хэрэг 14 нэгжээр буюу 56 хувиар тус тус буурсан байна.

## 2.7. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Энэ оны эхний улиралд Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 132 гомдол, мэдээлэл хүлээн авч материалжуулан шалгаж шийдвэрлэсэн. Гудамж замын хяналт шалгалтаар нийт 3507 зөрчил илрүүлсэн. Үүнээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 80 зөрчил илрүүлж 63 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1-д зааснаар 1 жилийн хугацаагаар хасаж, шийтгэлийн хуудсаар 25.200.000 төгрөгөөр торгож, эрхийн үнэмлэхгүй буюу эрх хасагдсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 17 иргэнийг Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, эрхийн үнэмлэхгүй болон эрх хасагдсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 103 жолоочид шийтгэл оногдуулж, 63 тээврийн хэрэгслийг түр саатуулж, Зөрчлийн тухай хууль тогтоомж зөрчсөн 3370 жолоочид бэлэн бусаар 81,755,000 төгрөгийн торгууль оногдуулж ажилласан.

Тээврийн цагдаагийн албаны даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 15-2/78 тоотор ирүүлсэн калындарчилсан төлөвлөгөөний дагуу “2020 онд аймгийн хэмжээнд техник, замын хяналтын чиглэлээр тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлын нэгдсэн хуваарь”-ийн дагуу “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийн бүрэн байдал”, “Тусгай дуут болон гэрлэн дохио”, “Авто замын эвдрэл” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж дүнг Тээврийн цагдаагийн албанд хүргүүлсэн.

“Сар шинэ 2020” нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг “Түмэнд нээлттэй хязгаарынхан” ХХК, “Ач буян трейвэл” ХХК-иар үйлчлүүлж буй зорчигчдыг Цагдаагийн байгууллагын “Асап” сантай тулгалт хийсэн.

Мөн “Итгэл хүлээлгэх өдөр” хэсэгчилсэн арга хэмжээг 2 өдөр зохион байгуулж зөрчил гаргасан жолооч нарт сануулж итгэлийн хуудас гардуулсан.

Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд иргэд, жолооч нарт 2 төрлийн зурагт хуудас, сэрэмжлүүлгийн эх хувийг бэлтгэн тээврийн хэрэгслийн жолоодох эрх сэргээх эрх бүхий “Цагдаагийн газрын Ахмад зөвлөл” төрийн бус байгууллагатай хамтран 500 ширхэгийг, Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн 4 төрлийн сэрэмжлүүлэг зурагт хуудсыг Албан журмын даатгагчдын холбооны Увс аймаг дахь салбартай хамтран 2000 ширхэгийг хэвлүүлэн иргэд, жолооч нарт тараасан.

Иргэн, аж ахуй нэгж байгууллагад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, зөрчлийг арилгуулахаар 12 мэдэгдэл хүргүүлж биелэлтийг хугацаанд нь авсан.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хилийн цэргийн 0245 ангийн алба хаагчдад энэ оны 1 дүгээр сард “Замын хөдөлгөөний дүрэм”-ийн мэдлэг олгох 1 цагийн сургалт явуулсан.

“Тусгай дуут болон гэрлэн дохио” ашиглах зөвшөөрөлтэй албан байгууллагын жолооч нарт 1 цагийн цахим сургалтыг зохион байгуулсан.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болох “МВС”, Увс нам бус”, “Увс” телевизээр замын хөдөлгөөнтэй холбоотой цаг үеийн мэдээ, мэдээлэл, аймгийн

хэмжээнд гарсан зам тээврийн осол, осол гарсан шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг 16 удаа өгсөн байна.

Замын халтиргаа, гулгааг арилгуулах зорилгоор “Увс АЗЗА” ТӨХК, “Улаангом Хот Тохижилт” ОНТҮГ-т албан мэдэгдэл хүргүүлж улсын чанартай авто замд 8 удаа, Улаангом сумын доторх хөдөлгөөнд 5 удаагийн цэвэрлэгээ, арчлалт, үйлчилгээ хийлгүүлсэн байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс Замын цагдаагийн тасагт ашиглагдаж байгаа бэлэн бус торгуулийн 17 ширхэг шалгах багажны дата эрх сэргээх 2.040.000 төгрөгийн асуудлыг шийдвэрлүүлсэн. Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор Улаангом сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас согтуурал тандагч багаж шийдвэрлүүлэх хүсэлтийг хүргүүлж, 3.100.000 төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг согтуурал тандагч багаж шийдвэрлүүлсэн.

Улаангом сум доторх авто замын тэмдэг, тэмдэглэл хуучирч муудсан, бүдгэрч арилсан шинээр солих шаардлагатай тэмдгийн судалгааг гаргаж, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлснээр 2020 оны төсөвт 110 сая төгрөгийн тэмдэг, тэмдэглэл хийлгэх хөрөнгийг шийдвэрлүүлсэн.

Улс, аймгийн онцгой комиссоос гарсан шийдвэр, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албанаас өгсөн үүрэг, чиглэлийн хүрээнд Увс аймгийн төв, сумдыг бүслэн хаах батлагдсан төлөвлөгөөний дагуу аймаг, сумын хөдөлгөөнд хяналт тавих пост гаргаж ажилласан.

Аймгийн төвд 8 пост, 18 суманд 46 постыг 24 цагаар ажлуулж давхардсан тоогоор 512 офицер, 432 цагдаа, 132 автомашинтай нийт 944 алба хаагч ажиллаж аймгийн төв болон сумд руу орж, гарсан 2991 тээврийн хэрэгсэл, 10075 хүнд хяналт тавьж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

#### *Гурав. Дүгнэлт*

Тус цагдаагийн газрын “Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах баг” нь урд оны эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, холбогдох тасаг, хэсэгт зөвлөмж хүргүүлж, улмаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй зохион байгуулсаны үр дүнд тодорхой төрлийн гэмт хэргүүд буурсан байна.

Тухайлбал аймгийн хэмжээнд энэ оны 1 дүгээр улирлын байдлаар 45 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 нэгжээр буюу 30.8 хувиар буурсан.

Үүнээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 1 нэгжээр буюу 100 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5 нэгжээр буюу 23.8 хувиар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 6 нэгжээр буюу 66.7 хувиар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 9 нэгжээр буюу 33.3 хувиар, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 1 нэгжээр буюу 5.3 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 5 нэгжээр буюу 71.4 хувиар, орон сууцанл үйлдэгдсэн гэмт хэрэг 14 нэгжээр буюу 56 хувиар тус тус буурчээ:

Тус цагдаагийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тодорхой үр дүнтэй зохион байгуулсан байна.

#### *Дөрөв. Санал*

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах ажлын туршлага солилцох уулзалт, зөвлөгөөнийг ЦЕГ-ын даргын зөвлөлийн гишүүнээр ахлуулан бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах.

ТАЙЛАГНАСАН: ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Н.МИШИГДОРЖ

ХЯНАСАН: ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Б.МӨНХБАТ